

**“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ГАЛ УНТРААХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН
МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн хуралдааны тухай хуулийн 75¹ дүгээр зүйлийн 75^{1.1}-д заасныг баримтлан дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс уг Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын байгууллагад нэн шаардлагатай гал түймэр унтраах автомашин болон цаашид гал унтраах ангийг хүчин чадал өндөр, шинэ үеийн тоног төхөөрөмжөөр хангахаар төлөвлөснийг дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, М.Оюунчимэг, Ч.Ундрам нар зээлийн хэлэлцээрийг зөвшилцөхийг дэмжиж, төсөлд тусгагдсан техник, тоног төхөөрөмжийг хүн амын төвлөрөл ихтэй сум, алслагдсан бүс нутагт хуваарилах боломжтой эсэх, төслийн хөрөнгөөр Онцгой байдлын ерөнхий газарт нисдэг тэрэг шинээр нэмж авах боломжийн талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ЦЭРЭНПУНЦАГ